



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

# МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2021 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛ



Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo> цахим хаяг эсхүл дээрх QR кодыг ашиглан бусад танилцуулга, мэдээтэй танилцана уу.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

## АГУУЛГА

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2021 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ .....	3
НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ .....	5
1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн: .....	5
1.2. Бодит ДНБ-ий өсөлт ба нэг хүнд ногдох ДНБ: .....	7
1.3 Бүтээмж, бүтээмжийн өсөлт: .....	7
ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ .....	9
2.1. Нэгдсэн төсвийн орлого: .....	9
2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага: .....	11
2.3. Төсвийн тэнцэл: .....	12
ГУРАВ. ГАДААД ХУДАЛДАА .....	13
3.1. Гадаад худалдааны эргэлт: .....	13
3.2. Экспорт: .....	14
3.3. Импорт: .....	16
ДӨРӨВ. МӨНГӨ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ .....	17
4.1. Мөнгөний нийлүүлэлт: .....	17
4.2. Гадаад валютын албан нөөц: .....	18
4.3. Төлбөрийн тэнцэл: .....	19
ТАВ. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ .....	20
5.1. Хүн ам, ажил эрхлэлт: .....	20
5.2. Ажилгүйдэл: .....	20



## МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2021 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ



КОВИД-19 вирусын тархалт үргэлжилж, гадаад, дотоод эдийн засгийн нөхцөл өөрчлөгдсөнөөр эдийн засгийн өсөлт 2020 онд огцом саарч макро түвшний голлох үзүүлэлтүүд буурч эдийн засаг агшиж байсан бол 2021 оны нэгдүгээр улирлаас эдийн засаг сэргэж өсөлт үргэлжилж байна.

**Эдийн засаг 3.6 хувийн өсөлттэй гарлаа.** ДНБ-ий бодит өсөлт 2017-2019 онуудад дунджаар 6.3 хувийн өсөлттэй байсан бол 2020 оны нэгдүгээр улиралд ДНБ огцом буурч -10.7 хувьтай байсан. Харин 2021 оны нэгдүгээр улирлын байдлаар эдийн засаг 15.7 хувиар өсөж эхэлсэн ба 2021 оны гуравдугаар улирлын байдлаар 3.6 хувийн өсөлттэй гарлаа.

**Нэгдсэн төсвийн тэнцлийн алдагдал буурчээ.** Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2021 оны 3 дугаар улиралд 1,277.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Тайлант хугацаан дахь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 1,459.2 тэрбум төгрөгөөр, төлөвлөсөн дүнгээс 1,649.2 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

**Төсвийн орлогын хувьд:** Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 9,666.7 тэрбум төгрөг болж, тайлант хугацаанд орлогын төлөвлөгөө 0.1 хувь буюу 14.4 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна. Өнгөрсөн оны мөн үеэс 44.2 хувь буюу 2,963.0 тэрбум төгрөгөөр илүү төвлөрчээ.

**Төсвийн нийт зарлагын хувьд:** Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 12,579.4 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 87.0 хувийг зарцуулж 1,634.8 тэрбум төгрөгийг дутуу зарцуулжээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 1,503.9 тэрбум төгрөг буюу 15.9 хувиар өсөж 10,944.6 тэрбум төгрөг зарцуулагдсан байна.

**Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарч өмнөх оны мөн үеэс өсжээ.** 2021 оны 3 дугаар улирлын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт 11,531.3 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 27.1 хувь буюу 2,456.2 сая ам.доллараар өсөж, гадаад худалдааны тэнцэл 1,278.2 сая ам.долларын ашигтай гарсан байна.

**Мөнгөний нийлүүлэлт өслөө.** Мөнгөний нийлүүлэлт (M2 мөнгө) 27.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4.6 (20.4 хувь) их наяд төгрөгөөр өссөн байна.

**Хэрэглээний үнийн индекс өссөн.** Хэрэглээний үнийн улсын индекс улсын хэмжээнд 2021 оны 3 дугаар улирлын байдлаар 9.2 хувь гарсан нь өмнөх сараас 0.3 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 9.6 хувиар өссөн байна.

**Төлбөрийн тэнцэл алдагдалтай гарлаа.** Төлбөрийн тэнцэл 2021 оны 3 дугаар улирлын байдлаар 1.8 тэрбум ам.долларын алдагдалтай гарсан. Энэ нь өмнөх оны мөн үеэс 1.1 тэрбум ам.доллаар өссөн үзүүлэлт байна.

**Үнэт цаасны арилжаа өсжээ.** Үнэт цаасны арилжаагаар 2021 оны 9 дүгээр сард 1.1 их наяд төгрөгийн гүйлгээ хийж, 523.6 сая ширхэг үнэт цаас арилжсан нь өмнөх оны мөн үеэс гүйлгээ 1,058.1 тэрбум төгрөгөөр, арилжсан үнэт цаас 313.5 сая ширхгээр тус тус өсжээ.

**Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш тогтвортой байна.** 2021 оны 9 дүгээр сарын байдлаар Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 2,848.9 төгрөг байгаа нь өмнөх сар болон оны эхний түвшинд тогтвортой байна. Мөн төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 441.19 төгрөг болж өмнөх оны мөн үеэс 22.19 төгрөгөөр, өмнөх сараас 1.28 төгрөгөөр суларсан байна.

**Хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн хэмжээ өссөн байна.** Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2021 оны 9 дүгээр сарын эцэст 1.1 их наяд төгрөг болж, өмнөх сараас 135.9 (11.3 хувь) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 78.6 (6.9 хувь) тэрбум төгрөгөөр тус тус буурчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 5.3 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.3 нэгж хувиар буурчээ. Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2021 оны 9 дүгээр сарын эцэст 2.0 их наяд төгрөг болж, өмнөх сараас 8.0 (0.4 хувь) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 13.4 (0.7 хувь) тэрбум төгрөгөөр өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 9.8 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.5 нэгж хувиар буурчээ.

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**



## НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ

### 1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн:

### Эцсийн ашиглалтын аргаар тооцсон Дотоодын нийт бүтээгдэхүүн

2021 оны гуравдугаар улирлын гүйцэтгэлээр 30.9 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 3.6 их наяд төгрөг буюу 11.3 хувиар өсчээ.

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон Монгол Улсын Дотоодын нийт бүтээгдэхүүн 2017 оны мөн үед 20.1 их наяд, 2018 оны мөн үед 23.2 их наяд, 2019 оны мөн үед 27.4 их наяд, 2020 оны мөн үед 27.3 их наяд төгрөгт хүрч байсан бол 2021 оны гуравдугаар улиралд 30.9 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 3.6 их наяд төгрөгөөр буюу 11.3 хувиар өссөн байна.


Зураг 1. ДНБ, эцсийн ашиглалтын аргаар, оны үнээр /их наяд төгрөг/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2021 оны гуравдугаар улирлын гүйцэтгэлээр 2015 оны зэрэгцүүлэх үнээр ДНБ 19.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 643.6 тэрбум төгрөгөөр буюу 3.4 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан байна.

Зураг 2. ДНБ, эцсийн ашиглалтын аргаар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр /их наяд төгрөг/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2021 оны гуравдугаар улирлын байдлаар ДНБ-ий 66.1 хувь нь эцсийн хэрэглээнд, 39.5 хувь нь хөрөнгийн нийт хуримтлалд, -5.6 хувь нь цэвэр экспортод ногдож байна.

### Үйлдвэрлэлийн аргаар тооцсон Дотоодын нийт бүтээгдэхүүн

Үйлдвэрлэлийн аргаар тооцсон Дотоодын нийт бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 3.0 (11.3 хувь) их наяд төгрөгөөр, 2015 оны зэрэгцүүлэх үнээр 19.5 их наяд төгрөгөөр өслөө.



Хүснэгт 1. ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр /тэрбум төгрөг/

Бүрэлдэхүүн	2017-III	2018-III	2019-III	2020-III	2021-III
ДНБ	20,262.2	23,705.6	27,617.2	26,579.2	29,577.2
Хөдөө аж ахуй ойн аж ахуй загас барилт ан агнуур	2,613.7	3,122.5	3,346.5	3,871.3	4,011.0
Уул уурхай, олборлолт	4,967.7	5,968.0	7,236.5	5,682.5	6,990.5
Боловсруулах үйлдвэрлэл	1,324.9	1,569.0	1,752.8	1,681.9	2,000.0
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	429.2	491.9	556.0	585.2	654.7
Барилга	457.3	474.5	617.4	660.3	542.9
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	1,585.2	1,783.8	2,187.4	2,023.1	2,341.6
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1,063.1	1,268.7	1,346.1	1,098.9	1,034.4
Мэдээлэл, холбоо	360.4	422.0	485.1	534.7	603.3
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	5,650.6	6,098.6	7,174.9	7,814.5	8,119.0
Бүтээгдэхүүний цэвэр татвар	1,810.3	2,506.6	2,914.5	2,626.8	3,279.8

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүснэгт 2. ДНБ-ий өөрчлөлтөд салбаруудын оролцоо, нэгж хувиар, жил бүрийн 3 дугаар улиралд

Бүрэлдэхүүн	2017-III	2018-III	2019-III	2020-III
ДНБ	7.0	6.8	-6.7	3.6
Хөдөө аж ахуй	0.7	0.2	1.6	-0.8
Уул уурхай, олборлолт	0.2	1.0	-3.3	1.4
Аж үйлдвэр, барилга	0.9	0.7	-0.4	-0.4
Боловсруулах үйлдвэрлэл	0.9	0.2	-0.4	0.4
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.2	0.1	0.0	0.2
Барилга	-0.1	0.4	-0.1	-1.1
Үйлчилгээ	2.6	3.6	-3.4	1.5
Бөөний болон жижиглэн худалдаа	0.3	1.5	-1.6	0.8
Тээвэр, мэдээлэл, холбоо	0.9	0.8	-1.0	-0.1
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1.5	1.4	-0.8	0.7
Бүтээгдэхүүний цэвэр татвар	2.5	1.4	-1.1	1.9

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2021 оны гуравдугаар улирлын гүйцэтгэлээр үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ 3.6 хувиар өссөний 1.4 нэгж хувь нь уул уурхай, олборлолтын салбарт, 1.5 нэгж хувь нь үйлчилгээний салбарт, 1.9 нэгж хувь нь бүтээгдэхүүний цэвэр татварт тус тус ноогдож байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад бүтээгдэхүүний цэвэр татвар 2.8 хувиар, үйлчилгээний салбар 4.9 хувиар, уул уурхайн, олборлолтын салбар 4.7 хувиар тус тус өссөн байна.

Зураг 3. ДНБ-ий хэмжээ, жил бүрийн 3 улиралд /их наяд төгрөгөөр/




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

## 1.2. Бодит ДНБ-ий өсөлт ба нэг хүнд ногдох ДНБ:

ДНБ-ий бодит өсөлт 2016 оны гуравдугаар улирлын байдлаар -1.4 хувь буюу хамгийн доод цэгтээ хүрсэн. Харин 2017-2019 онуудад дунджаар 6.3 хувийн өсөлттэй байсан бол 2021 оны нэгдүгээр улиралд Монгол Улсын эдийн засаг 15.7 хувиар өсөж эдийн засаг сэргэж эхэлсэн бөгөөд 2021 оны гуравдугаар улирлын байдлаар 3.6 хувийн өсөлттэй байна.


Зураг 4. Эдийн засгийн өсөлт, 1 хүнд ногдох ДНБ-ий хэмжээ, мян.төг



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2011 онд ДНБ-ий бодит өсөлт 17.3 хувь байх үед нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 4,917.1 мянган төгрөг байж энэ үеэс нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ өсөх хандлага ажиглагдсан. 2019 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр ДНБ-ий өсөлт 5.6 хувьд хүрэх үед нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 11,855.6 мянган төгрөг буюу хамгийн өндөр утгандаа хүрчээ. 2020 онд нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ буурч 2019 оны мөн үеэс 2.0 хувь буюу 242.7 мянган төгрөгөөр буурч 11,612.9 мянган төгрөг болсон байна.

Зураг 5. Эдийн засгийн өсөлт, улирлаар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн 2016-2020 оны төлөвийг авч үзвэл, 2016-2018 оны байдлаар 1.2-7.2 хувь хүртэл тогтмол өсөж байсан бол 2019 оны хоёрдугаар улирлаас эхлэн буурчээ. 2019 оны жилийн эцсийн өсөлтийн хувийг 2018 оны мөн үетэй харьцуулахад 2.0 пунктээр буурч 5.2 хувьд хүрсэн бол 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр -5.3 хувьд хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.5 пунктээр буурсан үзүүлэлттэй гарчээ.

## 1.3. Бүтээмж, бүтээмжийн өсөлт:

Бүтээмжийг илэрхийлэх гол үзүүлэх болох нэг ажиллагчид ногдох ДНБ (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2021 оны гуравдугаар улиралд 5.8 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 127.6 (2.3 хувь) мянган төгрөгөөр өссөн байна.

## ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1,277.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

2021 оны гуравдугаар улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 9,666.7 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 10,944.6 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1,277.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

2021 оны гуравдугаар улирлын гүйцэтгэлээр Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө 504.6 тэрбум төгрөгөөр, Орон нутгийн төсвийн орлого 23.9 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн бол Нийгмийн даатгалын сангийн орлого 155.3 тэрбум төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 14.3 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс давж биелсэн байна. Төсвийн нийт зарлага 1,634.8 тэрбум төгрөг буюу 13.0 хувиар дутуу зарцуулагджээ.

Хүснэгт 3. Монгол Улсын нэгдсэн төсөв /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2021 оны гуравдугаар улирал		Өөрчлөлт (+/-)	
	Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	9,652.3	9,666.7	14.4	0.1
Нийт зарлага цэвэр зээлийн дүн	12,579.3	10,944.6	-1,634.8	-13.0
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-2,927.0	-1,277.9	1,649.2	-56.3
Төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь	9.9	4.3	-5.6	-56.6

Эх сурвалж: Сангийн яам

2021 оны гуравдугаар улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн нь 9,666.7 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 2,963.0 тэрбум төгрөг буюу 44.2 хувиар, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 10,944.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 1,503.9 тэрбум төгрөг буюу 15.9 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 4. Нэгдсэн төсвийн өөрчлөлт, 2017-2021 оны гуравдугаар улирлын байдлаар /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Гуравдугаар улирал				Өөрчлөлт (+/-)	
	2018	2019	2020	2021	Дүн	Хувь
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	6,515.7	7,749.0	6,703.7	9,666.7	2,963.0	44.2
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	6,275.0	7,264.4	9,440.7	10,944.6	1,503.9	15.9
Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	241.7	484.6	-2,737.1	-1,277.9	1,459.2	-53.3
Төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь	0.8	1.8	10.3	4.3	-6.0	-58.3

Эх сурвалж: Сангийн яам, Үндэсний статистикийн хороо

2021 оны гуравдугаар улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1,277.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь өмнөх оны мөн үеэс 1,459.2 тэрбум төгрөгөөр буурсан байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь 4.3 хувь болж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 6.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцлийн алдагдал 2021 оны гуравдугаар улирлын гүйцэтгэлээр төлөвлөсөн дүнгээс 1,649.2 тэрбум төгрөгөөр буурсан байна.



## 2.1 Нэгдсэн төсвийн орлого

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 9,666.7 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 44.2 хувь буюу 2,963.0 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөн бол тайлант хугацаанд орлогын төлөвлөгөө 0.1 хувь буюу 14.4 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна. Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 88.0 хувийг татварын орлого, 12.0 хувийг татварын бус орлого эзэлж байна.

Нийт тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шатлал бүрээр авч үзвэл Орон нутгийн төсөв 0.9 хувь буюу 23.9 тэрбум төгрөгөөр, Улсын төсвийн орлого 6.8 хувь буюу 504.6 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс дутуу төвлөрсөн бол Нийгмийн даатгалын сангийн орлого 9.0 хувь буюу 155.3 тэрбум, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 2.0 хувь буюу 14.3 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 47.8 хувь буюу 2,229.1 тэрбум төгрөгөөр, Орон нутгийн төсвийн орлого 13.3 хувь буюу 308.5 тэрбум, Нийгмийн даатгалын сангийн орлого 22.4 хувь буюу 345.6 тэрбум, Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 126.1 хувь буюу 407.5 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Хүснэгт 5. Нэгдсэн төсвийн орлогын 2021 оны 3 дугаар улирлын гүйцэтгэл, төсвийн шатлалаар


Ангилал	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төлөв.	Гүйц.	Төлөв.	Гүйц.	Төлөв.	Гүйц.	Төлөв.	Гүйц.
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	8,589.6	8,356.1	2,644.9	2,621.1	1,733.0	1,888.3	716.4	730.7
ИРЭЭДҮЙН ӨВ САН	811.2	936.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	385.9	531.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	7,392.6	6,888.0	2,644.9	2,621.1	1,733.0	1,888.3	716.4	730.7
Татварын орлого	5,974.2	5,833.9	1,123.0	1,134.4	1,283.7	1,438.9	716.4	730.7
Орлогын албан татвар	1,954.4	1,904.8	754.2	761.4	0.0	0.0	0.0	0.0
Нийгмийн даатгалын орлого	0.0	0.0	0.0	0.0	1,283.7	1,438.9	716.4	730.7
Хөрөнгийн албан татвар	0.0	0.0	144.1	136.4	0.0	0.0	0.0	0.0
Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,037.8	2,081.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Онцгой албан татвар	642.0	637.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тусгай зориулалтын орлого	11.0	10.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Гадаад үйл ажиллагааны орлого	692.3	699.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар, төлбөр, хураамж	636.7	500.4	224.7	236.7	0.0	0.0	0.0	0.0
Татварын бус орлого	1,418.4	1,054.1	1,522.0	1,486.6	449.3	449.3	0.0	0.0
Нийтлэг татварын бус орлого	894.2	856.1	186.5	176.0	0.0	0.0	0.0	0.0
Хөрөнгийн орлого	0.0	0.0	1.0	0.7	0.0	0.0	0.0	0.0
Тусламжийн орлого	139.6	144.3	12.3	5.4	449.3	449.3	0.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам

Татварын орлого 8,504.8 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 0.8 хувь буюу 63.5 тэрбум төгрөгөөр давж биелжээ.

Татварын орлогын 31.4 хувийг орлогын албан татвар, 18.1 хувийг нийгмийн даатгалын орлого, 1.6 хувийг хөрөнгийн албан татвар, 24.5 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 7.5 хувийг онцгой албан татвар, 0.1 хувийг тусгай зориулалтын орлого, 8.2 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 8.7 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлж байна.

Зураг 6. Татварын орлого / тэрбум төгрөг/



Эх сурвалж: Сангийн яам

Тайлант хугацаанд татварын орлого 0.8 хувь буюу 63.5 тэрбум төгрөгөөр давж биелсэн нь нийгмийн даатгалын орлого 14.3 хувиар буюу 192.3 тэрбум төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвар 2.1 хувиар буюу 43.5 тэрбум төгрөг, гадаад үйл ажиллагааны орлого 1.0 хувиар буюу 6.9 тэрбум тус тус төлөвлөснөөс давж биелсэнтэй холбоотой байна.


Төлөвлөгөөтэй харьцуулахад орлогын албан татвар 42.3 тэрбум төгрөг (1.6 хувь), хөрөнгийн албан татвар 7.8 тэрбум төгрөг (5.4 хувь), онцгой албан татвар 4.6 тэрбум төгрөг (0.7 хувь), тусгай зориулалтын орлого 0.3 тэрбум төгрөг (2.4 хувь), бусад татвар, төлбөр хураамжийн орлого 124.3 тэрбум төгрөг (14.4 хувь)-өөр төлөвлөгөөнөөс дутуу гүйцэтгэлтэй гарчээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2021 оны 3 дугаар улирлын гүйцэтгэлээр татварын орлого 39.6 хувь буюу 2,414.1 тэрбум төгрөгөөр өсөхөд тусгай зориулалтын орлого 12.4 хувь буюу 1.5 тэрбум төгрөгөөр буурсан ч орлогын албан татвар 83.3 хувь буюу 1,211.7 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын орлого 24.8 хувь буюу 305.6 тэрбум төгрөг, хөрөнгийн албан татвар 19.4 хувь буюу 22.1 тэрбум төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвар 28.6 хувь буюу 462.4 тэрбум төгрөг, онцгой албан татвар 9.8 хувь буюу 56.9 тэрбум төгрөг, гадаад үйл ажиллагааны орлого 27.1 хувь буюу 149.0 тэрбум төгрөг, бусад татвар, төлбөр, хураамж 39.3 хувь буюу 207.8 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлжээ.

Татварын бус орлого 1,161.9 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 548.9 тэрбум төгрөгөөр өссөн бол төлөвлөснөөс 89.5 тэрбум төгрөг буюу 4.1 хувиар дутуу биелжээ.

Татварын бус орлого дутуу төвлөрөхөд төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого 0.3 тэрбум төгрөгөөр, гадаад хандив тусламжийн орлого 0.2 тэрбум төгрөгөөр, нийтлэг татварын бус орлого 48.6 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрсөн нь нөлөөлжээ. Харин газрын тосны орлого 30.5 тэрбум төгрөгөөр, торгуулийн орлого 19.3 тэрбум төгрөгөөр, бусад орлого 5.2 тэрбум төгрөгөөр, түрээсийн орлого 21.1 сая төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Зураг 7. Татварын бус орлогын бүтэц



Эх сурвалж: Сангийн яам

Татварын бус орлогын 88.8 хувийг нийтлэг татварын бус орлого, 11.1 хувийг тусламжийн орлого, 0.1 хувийг хөрөнгийн орлого эзэлж байна. Нийтлэг татварын бус орлогыг бүрдүүлэгч эх үүсвэрүүдийг бүтцийн хувьд авч үзвэл 2.3 хувийг хувьцааны ногдол ашиг, 3.9 хувийг хүүгийн орлого, 7.3 хувийг торгуулийн орлого, 22.6 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 0.3 хувийг түрээсийн орлого, 15.7 хувийг газрын тосны орлого, 6.3 хувийг навигацийн орлого эзэлсэн бол 41.7 хувийг бусад орлого бүрдүүлж байна.

## 2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 12,579.4 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 87.0 хувийг зарцуулж 1,634.8 тэрбум төгрөгийг дутуу зарцуулжээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 1,503.9 тэрбум төгрөг буюу 15.9 хувиар өсөж 10,944.6 тэрбум төгрөг зарцуулагдсан байна.

Тайлант хугацаанд улсын төсвийн зарлага төлөвлөснөөс 1,112.3 тэрбум төгрөг, орон нутгийн төсвийн зарлага 1,014.8 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсан бол нийгмийн даатгалын сангийн зарлага 52.0 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 67.0 тэрбум төгрөгөөр илүү зарцуулагджээ.

Өмнөх оны мөн үеэс улсын төсвийн нийт зарлага 1,280.3 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын сангийн зарлага 65.9 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 604.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж зарцуулагдсан бол орон нутгийн төсвийн зарлага 118.7 тэрбум төгрөгөөр буурчээ.

Хүснэгт 6. Нэгдсэн төсвийн зарлага /тэрбум төгрөг/

НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	ӨО-ны мөн үе	2021 оны 3 дугаар улирлын гүйцэтгэл			
		Төлөв.	Гүйц.	Зөрүү	Хувь
	9,440.7	12,579.4	10,944.6	87.0	-1,634.8
<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	<b>9,427.3</b>	<b>12,878.3</b>	<b>10,842.2</b>	<b>84.2</b>	<b>-2,036.1</b>
УРСГАЛ ЗАРДАЛ	7,497.0	10,608.7	9,270.7	87.4	-1,338.0
БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,181.8	3,815.6	2,972.1	77.9	-843.6
ХҮҮ	578.7	690.2	580.2	84.1	-110.0
ТАТААС	272.0	371.1	300.7	81.0	-70.4
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	77.0	65.1	44.4	68.2	-20.7
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	195.0	305.9	256.3	83.8	-49.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,464.4	5,731.8	5,417.7	94.5	-314.1
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,930.3	2,269.6	1,571.5	69.2	-698.1
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	13.5	-299.0	102.3	-34.2	401.3

Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн өнгөрсөн оны мөн үеэс 15.9 хувь буюу 1,503.9 тэрбум төгрөгөөр өсөхөд хөрөнгийн зардал 18.6 хувь буюу 358.8 тэрбум төгрөгөөр буурсан ч урсгал зардал 23.7 хувь буюу 1,773.8 тэрбум, цэвэр зээл 88.9 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Зээлийн үйлчилгээний төлбөр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.3 хувь буюу 1.5 тэрбум төгрөгөөр өссөн бол тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 15.9 хувь буюу 110.0 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулалттай гарсан байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлагын 84.7 хувь буюу 9,270.7 тэрбум төгрөгийг урсгал зардал, нийт урсгал зардлын 58.4 хувийг урсгал шилжүүлэг, 32.1 хувийг бараа, үйлчилгээний зардал, 6.3 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 3.2 хувийг татаас тус тус эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн урсгал зардал 1,773.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Бараа, үйлчилгээний зардал 209.8 тэрбум төгрөгөөр буурсан ч зээлийн үйлчилгээний төлбөр 1.5 тэрбум төгрөг, татаас 28.7 тэрбум төгрөг, урсгал шилжүүлэг 1,953.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлжээ.

2.3. Төсвийн тэнцэл

2021 оны гуравдугаар улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл -1,277.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий -4.3 хувьтай тэнцэх хэмжээний алдагдалтай гарсан байна.

Хүснэгт 7. Төсвийн тэнцэл /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Жил бүрийн 3-р улирал (өссөн дүнгээр)				Өөрчлөлт (+/-)	
	2018	2019	2020	2021	Дүн	Хувь
Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	241.7	484.6	-2,737.1	-1,277.9	1,459.2	-53.3
Төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь	0.8	1.8	-10.3	-4.3	-6.0	-58.3

Эх сурвалж: Сангийн яам

2021 оны 3 дугаар улирлын байдлаар гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 598.5 тэрбум төгрөг төлсөн бол урт хугацаат дотоод бондын үндсэн төлбөрт 90.5 тэрбум төгрөг төлөгдсөн байна. Гадаад төслийн зээлд 632.5 тэрбум төгрөг, 285.0 тэрбум төгрөгийн хөтөлбөрийн зээл шинээр авсан гүйцэтгэлтэй байна. Урт хугацаат 2,802.1 тэрбум төгрөгийн гадаад бонд шинээр гарсан байна.

**ГУРАВ. ГАДААД ХУДАЛДАА**

**3.1. Гадаад худалдааны эргэлт:**

**Гадаад худалдааны нийт бараа эргэлт:** Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2021 оны гуравдугаар улирлын гүйцэтгэлээр 11,531.3 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 27.1 хувь буюу 2,456.2 сая ам.доллараар өсөж гадаад худалдааны тэнцэл 1,278.2 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Хүснэгт 8. Гадаад худалдааны үзүүлэлт /сая ам.доллар/

Үзүүлэлт	Жил бүрийн 3-р улирал (өссөн дүнгээр)				Өөрчлөлт /өмнөх оны мөн үеэс/	
	2018	2019	2020	2021	Дүн	Хувь
Нийт эргэлтийн бараа	9,633.8	10,544.9	9,075.2	11,531.3	2,456.2	27.1
-Экспорт	5,282.8	5,946.1	5,147.0	6,404.7	1,257.7	24.4
-Импорт	4,351.1	4,598.8	3,928.1	5,126.6	1,198.4	30.5
Тэнцэл	931.7	1,347.3	1,218.9	1,278.2	59.3	4.9

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

**Гадаад худалдааны тэнцэл:** 2021 оны гуравдугаар улирлын байдлаар гадаад худалдааны тэнцэл 1,278.2 сая ам.долларын ашигтай гарсан байна. Өмнөх оны мөн үеэс 59.3 сая ам.доллар буюу 4.9 хувиар өсөхөд импорт 1,198.4 сая ам.доллар, экспорт 1,257.7 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

**Хөрш орнуудтай хийсэн худалдаа:** Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл БНХАУ-тай 2021 оны гуравдугаар улиралд 7.7 тэрбум ам.долларын, ОХУ-тай 1.4 тэрбум ам.долларын худалдаа хийжээ. ОХУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 26.9 хувиар, БНХАУ-тай хийсэн худалдаа 47.2 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 9. Хөрш орнуудын гадаад худалдааны үзүүлэлт /сая ам.доллар/

Улс	Төрөл	Жил бүрийн 3-р улирал (өссөн дүнгээр)			Өөрчлөлт (+, -)	
		2019	2020	2021	2021.9/2020.9	
					Дүн	Хувь
БНХАУ	Нийт эргэлт	6,853.1	5,241.8	7,715.4	2,473.6	47.2%
	Экспорт	5,305.7	3,781.2	5,651.4	1,870.2	49.5%
	Импорт	1,547.4	1,406.6	2,064.0	657.4	46.7%
	Тэнцэл	3,758.3	2,374.6	3,587.4	1,212.8	51.1%
ОХУ	Нийт эргэлт	1,312.1	1,063.3	1,349.7	286.4	26.9%
	Экспорт	51.5	36.8	82.7	45.9	124.7%
	Импорт	1,260.6	1,026.5	1,347.9	321.4	31.3%
	Тэнцэл	-1,209.1	-989.7	-1,265.2	-275.5	27.8%
Бусад	Нийт эргэлт	2,379.6	2,770.0	2,385.3	-384.7	-13.9%
	Экспорт	588.8	1,329.0	670.6	-658.4	-49.5%
	Импорт	1,790.8	1,441.0	1,714.7	273.7	19.0%
	Тэнцэл	-1,202.0	-112.0	-1,044.1	-932.1	832.2%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Монгол Улсын гадаад худалдаа ОХУ болон бусад орнуудтай алдагдалтай, БНХАУ-тай ашигтай гарсан байна.



### 3.2. Экспорт:

2021 оны 3 дугаар улирлын гүйцэтгэлээр 6,404.7 сая ам. долларт хүрч, эдийн засаг хэвийн байсан 2019 оны мөн үетэй харьцуулахад 458.6 сая ам.доллар буюу 7.7 хувиар, харин 2020 оны 3 дугаар улиралтай харьцуулахад 1,257.7 сая ам.доллар буюу 24.4 хувиар өссөн байна.

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт 5,384.0 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 1,767.0 сая ам.доллар буюу 48.9 хувиар өссөн бол эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт 1,020.8 сая ам.доллар болж, өмнөх оноос 509.3 сая ам.доллар буюу 33.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 10. Эрдсийн болон эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт /сая ам.доллар/

Үзүүлэлт	Жил бүрийн 3-р улирал (өссөн дүнгээр)				Өөрчлөлт (+/-)		Нийт экспортод эзлэх хувь
	2018	2019	2020	2021	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний экспорт	4,538.5	4,962.6	3,616.9	5,384.0	1,767.0	48.9	84.1
Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт	744.3	983.4	1,530.1	1,020.8	-509.3	-33.3	15.9
Нийт экспорт	5,282.8	5,946.1	5,147.0	6,404.7	1,257.7	24.4	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хүснэгт 11. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, төрлөөр

Барааны төрөл	Хэмжих нэгж	Жил бүрийн 3-р улирал (өссөн дүнгээр)				Өмнөх оны мөн үеэс	
		2018	2019	2020	2021	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	мян. тн	1,073.0	1,066.3	1,020.7	1,020.9	0.2	0.02
Нүүрс	сая. тн	27.0	28.6	19.8	12.0	-7.8	-39.5
Төмрийн хүдэр	сая. тн	5.3	6.1	6.3	5.9	-0.3	-4.9
Цайрын баяжмал	мян. тн	92.2	100.7	102.7	92.4	-10.3	-10.0
Алт	тн	3.4	7.5	20.2	7.9	-12.4	-61.1
Боловсруулаагүй нефть	сая. баррель	4.81	4.84	2.4	3.7	1.3	55.8
Катодын зэс	тн	10.0	7.4	6.2	7.8	1.60	26.0
Жоншны баяжмал	мян. тн	344.7	500.0	490.7	565.2	74.5	15.2
Адууны мах	мян. тн	16.7	14.4	8.4	7.0	-1.4	-16.2
Өлөн гэдэс	тн	306.7	310.0	399.4	395.4	-4.0	-1.0
Үхэр, адууны боловсруулсан шир	сая. дм2	57.3	55.4	23.4	7.5	-15.9	-68.0
Үхэр, адууны боловсруулаагүй шир	мян. ш	0.3	421.9	161.0	441.4	280.4	174.2
Хонь, хурганы боловсруулсан арьс	сая. дм2	91.1	43.5	40.7	66.3	25.5	62.7
Ямаа, ишигний боловсруулсан арьс	сая. дм2	103.0	108.2	76.3	65.6	-10.7	-14.1
Самнасан ноолуур	тн	422.3	371.1	202.5	284.6	82.0	40.5
Бохир ноолуур	тн	5,108.3	5,595.5	5,200.5	4,373.6	-826.9	-15.9
Хонины самнаагүй ноос	мян. тн	9.9	9.8	4.6	5.5	0.9	20.7

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хүснэгт 12. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын орлого /сая ам.доллар/

Барааны төрөл	Жил бүрийн 3-р улирал (өссөн дүнгээр)				Өмнөх оны мөн үеэс	
	2018	2019	2020	2021	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	1,487.6	1,421.0	1,166.3	2,307.3	1,141.0	97.8
Нүүрс	2,122.3	2,434.8	1,476.0	1,501.6	25.6	1.7
Төмрийн хүдэр	240.4	422.3	463.3	847.8	384.5	83.0
Цайрын баяжмал	153.5	145.1	124.2	142.9	18.7	15.0
Алт	144.5	344.3	1,166.1	460.0	-706.1	-60.6
Боловсруулаагүй нефть	316.1	271.7	85.9	224.3	138.4	161.1
Катодын зэс	65.2	43.4	33.5	68.8	35.3	105.5
Жоншны баяжмал	115.7	155.1	115.5	124.7	9.2	8.0
Адууны мах	36.1	27.5	15.6	14.6	-1.0	-6.5
Өлөн гэдэс	5.8	6.1	6.4	9.5	3.1	48.0
Үхэр, адууны боловсруулсан шир	6.3	5.3	2.3	0.8	-1.5	-65.3
Үхэр, адууны боловсруулаагүй шир	0.01	1.3	0.2	0.7	0.5	210.1
Хонь, хурганы боловсруулсан арьс	6.3	5.3	0.9	1.3	0.4	44.1
Ямаа, ишигний боловсруулсан арьс	3.7	3.6	2.7	2.2	-0.5	-20.0
Самнасан ноолуур	36.2	32.9	13.2	24.7	11.5	86.8
Бохир ноолуур	242.3	280.2	151.5	176.0	24.5	16.1
Хонины самнаагүй ноос	15.9	13.9	4.4	5.7	1.2	28.1
Нийт экспортод эзлэх хувь	94.6%	94.4%	93.8%	92.3%		

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Нийт экспортын 36.0 хувийг зэсийн баяжмал, 23.4 хувийг нүүрс, 13.2 хувийг төмрийн хүдэр ба баяжмал, 7.2 хувийг боловсруулаагүй алт, 3.5 хувийг боловсруулаагүй нефть, 2.2 хувийг цайрын хүдэр ба баяжмал, 1.9 хувийг жоншны хүдэр эзэлсэн байна. Эрдсийн бүтээгдэхүүний экспорт өнгөрсөн оны мөн үеэс 1,767.0 сая ам.доллар буюу 48.9 хувиар өсөхөд голлон нөлөөлсөн бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл:

**Нүүрс:** 2021 оны 3 дугаар улирлын байдлаар 12.0 сая тонн нүүрс экспортолж, 1,501.6 сая ам.долларын экспортын орлого олжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нүүрсний экспортын биет хэмжээ 7.8 сая тонноор буурсан боловч экспортын орлого 25.6 сая ам.доллараар буюу 1.7 хувиар өссөн байна. Нэг тонн нүүрсний экспортын дундаж үнэ өмнөх оны мөн үеэс 50.6 ам.доллар буюу 67.9 хувиар нэмэгдсэн нь нүүрсний экспортын орлого өсөхөд нөлөөлжээ.

**Зэсийн баяжмал:** 2021 оны 3 дугаар улирлын байдлаар зэсийн баяжмалын экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс 97.8 хувь буюу 1,141.0 сая ам.доллараар нэмэгдэж, 2,307.3 сая ам.долларт хүрсэн байна. Зэсийн баяжмалын экспортын биет тоо хэмжээ 1,020.9 мянган тонн болж өнгөрсөн оны мөн үеэс 0.02 хувь буюу 0.2 мянган тонноор өссөн ба экспортын дундаж үнэ нь 97.8 хувиар өссөн байна.

**Цайрын баяжмал:** 2021 оны 3 дугаар улирлын байдлаар цайрын баяжмалын экспортын тоо хэмжээ 92.4 мянган тоннд хүрч, 142.9 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Цайрын баяжмалын экспортын орлого өмнөх оны мөн үеэс 15.0 хувь буюу 18.7 сая ам.доллараар өсөхөд цайрын баяжмалын биет хэмжээ 10.0 хувь буюу 10.3 мянган тонноор буурсан боловч 1 тонн цайрын баяжмалын экспортын дундаж үнэ 27.9 хувиар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

### 3.3. Импорт

2021 оны 3 дугаар улирлын байдлаар импорт 5,126.6 сая ам.доллар болж 2019 оны мөн үетэй харьцуулахад 527.8 сая ам.доллар буюу 11.5 хувиар, 2020 оны мөн үеэс 1,198.4 сая ам.доллар буюу 30.5 хувиар тус тус өссөн байна. Уг өсөлтөд эрдэст бүтээгдэхүүний импорт 155.4 сая ам.доллаар, авто агаарын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд ангийн импорт 341.1 сая ам.доллаар, ачааны автомашины импорт 152.4 сая ам.доллаар өссөн нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 13. Эрдсийн бүтээгдэхүүний импорт /сая ам.доллар/

Үзүүлэлт	Жил бүрийн 3-р улирал (өссөн дүнгээр)				Өөрчлөлт (+/-)		Нийт импортод эзлэх хувь
	2018	2019	2020	2021	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний импорт	976.0	1,016.9	728.0	883.4	155.4	21.3	17.2
Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт	3,375.1	3,581.9	3,200.10	4,243.2	1,043.1	32.6	82.8
Нийт импорт	4,351.1	4,598.8	3,928.1	5,126.6	1,198.4	30.5	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

**ДӨРӨВ. МӨНГӨ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ****4.1. Мөнгөний нийлүүлэлт:**

Мөнгөний нийлүүлэлт 2021 оны гуравдугаар улирлын байдлаар 27.0 их наяд төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 4.6 их наяд төгрөг буюу 20.4 хувиар өссөн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад мөнгөний нийлүүлэлт нэмэгдэхэд бараг мөнгө 4.6 их наяд төгрөгөөр буюу 20.4 хувиар өссөн нь нөлөөлжээ. Валютын харилцах 39.9 тэрбум төгрөгөөр буюу 1.9 хувиар, төгрөгийн харилцах 1.9 их наяд төгрөгөөр буюу 67.2 хувиар, төгрөгийн хадгаламж 3.5 их наяд төгрөгөөр буюу 30.0 хувиар өссөн байна.

**Хүснэгт 14. Мөнгөний нийлүүлэлтийн үзүүлэлтүүд /тэрбум төгрөг/**

	2019 IX	2020 IX	2021		Өмнөх оны мөн үетэй харьцуулсан өөрчлөлт (+/-)	
			VIII	IX	Дүн	Хувь
Мөнгөний нийлүүлэлт (M2)	20,432.9	22,425.9	27,146.7	26,994.7	4,568.8	120.3
Бараг мөнгө	3,804.3	3,560.5	5,696.0	5,600.6	2,040.1	157.3
-Төгрөгийн хадгаламж	10,780.8	11,643.5	15,168.0	15,135.6	3,492.1	130.0
-Валютын хадгаламж	2,925.0	5,110.5	4,041.7	4,107.2	-1,003.3	80.4
-Валютын харилцах	2,922.8	2,111.4	2,241.0	2,151.3	39.9	101.9
M1 мөнгө	3,804.3	3,560.5	5,696.0	5,600.6	2,040.1	157.3
Гүйлгээнд гарсан бэлэн мөнгө	889.8	950.1	1,080.3	1,057.1	107.0	111.3

Эх сурвалж: Монголбанк

**Хүснэгт 15. Зээлийн өрийн үлдэгдэл /тэрбум төгрөг/**

Үзүүлэлт	Гуравдугаар улирлын гүйцэтгэл			Өмнөх оны мөн үетэй харьцуулсан өөрчлөлт (+/-)	
				2020.09/2021.09	
	2019	2020	2021	Дүн	Хувь
Зээлийн өрийн үлдэгдэл	18,151.1	17,348.5	20,205.9	2,857.4	16.5
- Хэвийн зээл	15,192.6	14,230.3	17,152.9	2,922.6	20.5
- Хугацаа хэтэрсэн зээл	985.6	1,147.1	1,068.5	-78.6	6.8
- Чанаргүй зээл	1,972.9	1,971.1	1,984.5	13.4	0.7
Чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх %	10.9	11.4	9.8	1.6	14.0
Хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх %	5.4	6.6	5.3	1.3	19.7

Эх сурвалж: Монголбанк

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2021 оны 9 дүгээр сарын эцэст 20.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 328.2 (1.7 хувь) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 2.9 (16.5 хувь) их наяд төгрөгөөр өссөн байна. Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 10.3 (50.8 хувь) их наяд төгрөг нь иргэдийнх байна.

**Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл** 2021 оны гуравдугаар улирлын эцэст 1.1 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 78.6 (6.9 хувь) тэрбум төгрөгөөр буурсан байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 5.3 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.3 нэгж хувиар буурсан байна.

**Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл** 2021 оны гуравдугаар улирлын эцэст 2.0 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 13.4 (0.7 хувь) тэрбум төгрөгөөр өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 9.8 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.5 нэгж хувиар буурчээ.

**Үнэт цаас:** Үнэт цаасны арилжаагаар 2021 оны гуравдугаар улирлын байдлаар 1.1 их наяд төгрөгийн гүйлгээ хийж, 523.6 сая ширхэг үнэт цаас арилжсан нь өмнөх оны мөн үеэс гүйлгээ 1,058.1 (31.4 дахин) тэрбум төгрөгөөр, арилжсан үнэт цаас 313.5 (2.5 дахин) сая ширхэгээр тус тус өсжээ.


Үнэт цаасны гүйлгээ 2021 оны гуравдугаар улиралд 46.1 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 376.0 (89.1 хувь) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 44.3 (25.5 дахин) тэрбум төгрөгөөр өсжээ. Харин арилжсан үнэт цаас 45.4 сая ширхэг болж, өмнөх сараас 53.9 (54.3 хувь) ширхэгээр буурч, өмнөх оны мөн үеэс 30.9 (3.1 дахин) сая ширхэгээр тус тус өсжээ.

Хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2021 оны гуравдугаар улиралд 44,824.4 нэгж болж, өмнөх сараас 9,672.3 нэгжээр өмнөх оны мөн үеэс 27,648.2 нэгжээр өссөн байна.

**Валютын ханш:** 2021 оны гуравдугаар улирлын байдлаар Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 2,848.9 төгрөг болж өмнөх оны мөн үеэс 5.2 төгрөгөөр чангарсан байна. Мөн төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 441.2 төгрөг болж өмнөх сараас 1.3 төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 22.2 төгрөгөөр суларсан байна..

**Хэрэглээний үнийн индекс:** Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2021 оны гуравдугаар улирлын байдлаар өмнөх сараас 0.3 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 9.6 хувиар, өмнөх оны эцсээс 9.2 хувь өссөн байна.


Зураг 8. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс (өмнөх оны мөн үеэс), хувь



#### 4.2. Гадаад валютын албан нөөц:

Нийт албан нөөцийн хэмжээ 2021 оны гуравдугаар улирлын байдлаар 4,180.9 сая ам.доллар байна. Гадаад валютын албан нөөц өмнөх оны мөн үеэс 483.1 сая ам.доллар буюу 11.5 хувиар нэмэгдсэн байна. 2020 сүүлийн хагасаас гадаад орчинд гарсан эерэг өөрчлөлт болон Монголбанканд тушаах алтны хэмжээ нэмэгдсэн зэрэг нь гадаад валютын албан нөөцийн хэмжээ өсөхөд нөлөөлжээ.


Зураг 9. Нийт гадаад валютын албан нөөц (сая ам.доллар)





Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ 2021 оны гуравдугаар улирлын эцэст 14,926.8 тонн болж, 2019 оны мөн үеэс 3,755.6 тонноор өссөн байна. Монголбанкны 1 грамм алт худалдан авах дундаж ханш 162,906.1 төгрөг байжээ.

Зураг 10. Алтны хэмжээ /кг/



#### 4.3. Төлбөрийн тэнцэл:

Төлбөрийн тэнцлийн урсгал данс 2021 оны гуравдугаар улирлын гүйцэтгэлээр 1.8 тэрбум ам.долларын алдагдалтай гарч, алдагдал өмнөх оны мөн үеэс 1.1 тэрбум ам.доллаар өсжээ. Тус өсөлтөд анхдагч орлогын алдагдал өмнөх оны мөн үеэс 717.8 сая ам.доллаар өсөж, 1.5 тэрбум ам.долларт хүрсэн нь голлон нөлөөлсөн байна. Урсгал дансны алдагдал 283.1 сая ам.доллар болж, өмнөх сараас 7.8 сая ам.доллаар буурчээ. Харин хөрөнгийн данс 99.9 сая ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 23.5 сая ам.доллаар өсжээ. Санхүүгийн дансны тэнцэл 2021 оны гуравдугаар улирлын байдлаар 1.4 тэрбум ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 866.3 сая ам.доллаар өсжээ.

Хүснэгт 16. Төлбөрийн тэнцлийн үндсэн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2020		2021	
	IX	I-IX	IX	I-IX
Үзүүлэлтүүд	Сая ам.доллар			
Урсгал данс	-44.4	-732.8	-283.1	-1,811.0
Хөрөнгийн данс	9.7	76.5	23.2	99.9
Санхүүгийн данс	146.9	-530.7	-107.5	-1,397.0
Алдаа болон орхигдуулга	107.8	-346.9	-16.6	-266.2
Нөөц хөрөнгө	-73.9	-472.5	-169.0	-580.3

Эх сурвалж: Монголбанк

## ТАВ. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

### 5.1. Ажилгүйдэл:

Ажиллах хүчний судалгааны 2021 оны гуравдугаар улирлын дүнгээр улсын хэмжээнд 15 ба түүнээс дээш насны нийт хүн амын 1,226.8 сая нь ажиллах хүч байна. Ажиллах хүчний 1.1 (92.6 хувь) сая нь ажиллагчид байгаа ба өмнөх оны мөн үеэс 40.1 (3.4 хувь) мянгаар буурчээ. Улсын хэмжээнд 15, түүнээс дээш насны хүн амын 893.8 (42.1 хувь) мянга нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна. Тэдгээрийн 54.2 (6.1 хувь) мянга нь цалин хөлс, орлого олох ажил хайх эсвэл хийх нөхцөл нь бүрдвэл ажиллах хүчний эгнээнд шилжихэд бэлэн байгаа боломжит ажиллах хүч байна. Хөдөлмөрийн дутуу ашиглалтын 153.4 мянга байгаагийн 54.2 (35.3 хувь) мянга нь боломжит ажиллах хүч, 90.9 (59.3 хувь) мянга нь ажилгүй хүн, 8.3 (5.4 хувь) мянга нь цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид байгаа нь өмнөх оны мөн үеэс 5.9 (3.7 хувь) мянгаар, өмнөх улирлаас 22.5 (12.8 хувь) мянган хүнээр буурсан байна.

Улсын хэмжээнд 2021 оны гуравдугаар улирлын байдлаар 54515 эх амаржиж, 54896 хүүхэд төрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эх 2541-ээр, төрсөн хүүхэд 2594-өөр тус тус буурч 1000 хүнд ногдох төрөлт өмнөх оны мөн үеэс 1.0 нэгж хувиар буурсан байна.

### 5.2. Хүн ам, ажил эрхлэлт:

Улсын хэмжээнд 2021 оны гуравдугаар улирлын байдлаар ажилгүй хүн 90.9 мянга байгаагийн 48.0 (52.8 хувь) мянга нь эрэгтэйчүүд, 42.9 (47.2 хувь) мянга нь эмэгтэйчүүд байна. Ажилгүй хүн өмнөх оны мөн үеэс 1.7 (1.9 хувь) мянга, өмнөх улирлаас 10.4 (10.3 хувь) мянгаар буурсан байна.

Ажилгүйдлийн түвшин улсын хэмжээнд 7.4 хувь байна. Хот, суурин газрын хүн амын ажилгүйдлийн түвшин 8.4 хувь буюу улсын дунджаас 1.0 нэгж хувиар илүү, харин хөдөө орон нутагт ажилгүйдлийн түвшин 5.1 хувь байгаа нь улсын дунджаас 2.3 нэгж хувиар доогуур байна.

Ажилгүйдлийн түвшинг бүсээр харахад Төвийн бүсэд 10.5 хувь байгаа нь улсын дунджаас 3.1 нэгж хувиар дээгүүр байна. Ажилгүйдлийн түвшинг аймгаар авч үзэхэд Ховд, Өмнөговь, Говьсүмбэр, Баянхонгор, Баян-Өлгий, Говь-Алтай, Дархан-Уул, Хөвсгөл, Орхон, Сэлэнгэ аймгууд улсын дунджаас 0.5-24.6 нэгж хувиар дээгүүр байна.

Ажилгүй хүмүүсийг боловсролын түвшнээр авч үзвэл, техникийн болон мэргэжлийн, тусгай мэргэжлийн дунд болон дээд боловсролтой ажилгүй хүмүүс нийт ажилгүйдлийн 67.6 хувь байгаа бол 32.4 хувь нь бүрэн дунд, түүнээс доош болон боловсролгүй иргэд байна.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС